

ОРОН НУТГИЙН ЭРХ БАРИХ ТӨЛӨӨЛӨГЧДИЙН БАЙГУУЛЛАГЫН ЭХ ҮҮСВЭР ТАВИГДСАН НЬ

М.Жавзансүрэн.

Боловсрол дээд сургууль. Түүх-Аялал жуулчлалын тэнхим

Өгүүллийн товч утга: 1990-ээд оноос өмнөх түүх бичлэгт орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын түүхийг марксист-ленинист хэлбэрээр бичиж байсныг хянан үзэж, үзэл суртлын хальс бүрхэвчээс салган, түүхийн шинжлэх ухааны онол, арга зүйн шинэ хандлагаар судлахыг хичээсэн болно.

Түлхүүр үг: орон нутгийн хурал, Хөдөлмөрчин ардын хурал, Депутат, Хөдөлмөрчдийн депутатын хурал, Ардын депутатын хурал

Монголын ард түмэн өнө эртний уламжлалтай төдийгүй айл гэр, ах дүү элгэн саднаараа нэгдэн “бүгдээрээ зөвлөвөл буруугүй бүлээн усаар угаавал хиргүй” хэмээн амьдралын болоод нутаг орныхоо тулгамдсан асуудлуудыг өөр хоорондоо зөвшилцөн, ахмадынхаа үг сургаал, туршлагад тулгуурлан шийдвэрлэж ирсэн хийгээд Ураг төрлийн байгууллын үеэс овог нийтийн эрх ашгийг илэрхийлж хэрэг явдлаа хэлэлцэн шийдвэр гаргадаг “Эе” гэдэг цуглаантай байсан нь нүүдэлчдийн соёл иргэншилд бий болгосон нутгийн өөрөө удирдах ёсны хэв шинжийн эх үүсвэр байсан.

Аргын тооллын өмнөх 209 онд Хүннү гүрэн байгуулагдсанаар төрт ёсны хоёр мянга гаруй жилийн түүхийн хуудас зузааран дэлхийд түүчээлэн яваа Америк мэтийн хүчирхэг орнуудын дэргэд төрт ёсны баялаг түүхтэй ард түмэн болсон билээ.

Төр бол аливаа улсын амин сүнс байдаг. Тэр утгаараа ардчиллын зарим бүрдлийг өөртөө багтаасан “аймгийн чуулган”, (Аймгийн чуулган нь манж жанжин амбасын хяналтын дор тухайн аймгийн бүх хэргийг зөвлөлдөн шийдвэрлэх газар¹) XX зуунд “ардын хурал”², “хөдөлмөрчин ардын хурлууд”³ байгуулагдаж нутаг нуга, улс орныхоо асуудлыг олуулаа буюу сонгосон төлөөлөгчөөр дамжуулан тал бүрээс нь тунгаан хэлэлцэж шийддэг, их, бага хаадаас эхлээд ард түмэн, иргэдийг төрийн хэрэгт оролцуулах “ардчиллын зорилго бүхий” ажиллагааг улам бүрээр хөгжүүлсээр иржээ.

“Монголын үнэн” сонины 1920 оны XI.10 ны дугаарт “Гадна, дотны мөлжих дарлах зүйлүүдийг шүүрдэн арилгаж, улс төрийн эрх мэдлийг ард олон өөрснөө эзлэн авч, чухам итгэлтэй үнэнхүү санаанаас олны тусыг хичээх хэрэг үйлсээ явуулан чадах шударга эрдэмтэй

¹ Болдбаатар.Ж. Лүндээжанцан.Д. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал.УБ.1997.тал 144

² 1924 оны үндсэн хууль. УБ.1924.Монгол улсын 14 он

³ Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004. тал 149

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

сайн хүн нарыг ард өөрснөө сонгож улсын засаг бариулна”⁴ хэмээгээд “21 насанд хүрсэн иргэд бүгдээрээ цуглан хуралдаж, сумын хурлыг байгуулаад, цааш цааш нь дээд шатны хурлыг шат дамжуулан сонгож байгуулах”⁵ тухай зааж өгсөн явдал нь орон нутгийн эрх барих байгууллагын эхлэл болж байв.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараах түүхэн үйл явцын нэг нь засгийн бүх эрхийг ард түмний гарт өгөх зорилт байсан бөгөөд үүнийг шийдэх эхний арга хэмжээ нь орон нутгийн засаг захиргааны асуудлыг цэгцэлж, ардын төлөөлөгчдийн байгууллагын эх үүсвэр болох хурлыг байгуулах явдал байсан юм.

Орон нутгийн засаг захиргааг өөрчлөх асуудал үндсэндээ 1923-1924 он хүртэл үргэлжилсэн ба баг, сумуудын хурлаар цаашид тавих зорилтоо тодорхойлж өгсөн байна.

1923-1925 онд “Монгол улсын нутгийн захиргааны дүрэм”, “Их шавийн захиргааны дүрэм”, “Ховдын харъяат газрын захиргааны дүрэм”, “Дарьгангын нутгийн захиргааны дүрэм”, “Улаанбаатар хотын захиргааны газрын дагаж явах дүрэм”⁶ зэргийг баталсан. Эдгээр дүрмийг үндэслэн засаг захиргааны байгууллага байгуулах ажил өрнөсөн бөгөөд үүний үр дүнд арван, гэр, хошуу, сум, багаас хурал байгуулжээ.

“Нутгийн захиргааны дүрэм” ёсоор арван гэрийн хурлууд бий болж, засаг захиргааны удирдлагад байгаа засаг ноёдыг ардын төлөөлөгчөөр сольсон явдлыг доктор М.Санждорж “... ард олны үндсэн ашиг сонирхлын асуудлууд хэлэлцэн нутгийн захиргааны эрх баригчдыг сонгосон нь тус орны түүхэнд урьд өмнө үзэгдээгүй улс төрийн гүн гүнзгий ач холбогдолтой цоо шинэ үзэгдэл байв” хэмээгээд “... Монголд төрийн эрх барих хурал хэмээх ардын төлөөлөгчдийн байгууллагын систем тогтжээ”⁷ хэмээн дүгнэсэн байдаг.

Академич Ж.Болдбаатар, доктор Д.Лүндээжанцан нар “Төрийг удирдах хэрэгт олон түмнийг өргөнөөр оролцуулах хэлбэр-арван гэр, баг, сум, хошуу, аймаг, шавийн төлөөлөгчдийн хурал шат дараалан байгуулагдсан нь ардын төлөөлөгчдийн байгууллагын нэгдмэл тогтолцоо төлөвшин хөгжих үндсийг бүрдүүлжээ” хэмээн төрийг удирдах хэрэгт олон түмнийг оролцуулсан нь чухал алхам болж чадсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Дээрх дүрмийг үндэслэн Монгол оронд ардчилсан засаг захиргааны байгууллага байгуулах ажил 1923-1924 онд хэрэгжсэн хийгээд Улсын анхдугаар хурлаар анхны Үндсэн

⁴ МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1920-1940. УБ. 1966. 17 тал

⁵ Мөн тэнд. тал 24

⁶ Сономдавга.Ц. БНМАУ-ын Орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд. УБ. 1967. тал

⁷ М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ. 1974. тал 116

хуулиа баталж, "... Бүгд найрамдах засгийг явуулан Улсын дээд эрхийг Улсын Их Хуралд хадгалуулахаар тогтоон зарласан учир бидний олон аймаг, хотуудын Хурлаас томилсон төлөөлөгчид бүгдээрээ цуглан хуралдахыг ..." онцлон зааж, хууль эрх зүйн хувьд баталгаажуулж өгсөн юм.

1924 оны Үндсэн хуулийг эрдэмтэн судлаачид "Монгол төрийн түүхнээ анх удаа хаант ёсыг халж, үндэсний ардчилсан өөрчлөлт, эрх зүйн чухал зарчмууд, улс төрийн цоо шинэ тогтолцоог хуульчлан баталгаажуулж, туурга тусгаар Бүгд найрамдах улсаа тунхаглан зарласнаараа түүхэн ач холбогдолтой баримт бичиг мөн" гэж дүгнэсэн байдаг. Түүнээс гадна орон нутгийн эрх барих байгууллагын анхны хууль зүйн акт болж чадсан гэдэг нь маргаангүй билээ.

1924 оны анхны Үндсэн хуулийн III бүлэг "Нутгийн захиргааны тухай" хэмээх хэсэгт "Нутгийн захиргааны хууль дүрмийн ёсоор аймаг, хошуу, сум, баг, арван гэр хүртэл олон хотын газар орон нутгийн хурлууд нь аливаа аж ахуй ба албаны хэргүүдийг гүйцэтгэн явуулахаар өөрсдийн дундаас аймаг, хошуу, сум, арван гэрийн аливаа хэрэг явдлыг гүйцэтгэх захиргааны газрыг сонгон байгуулахаас зохих хэмээн хуульчилж өгснөөр орон нутгийн хурлуудын үүргийг тодорхой болгосон. Үүнд:

Гучдугаар зүйл: Нутгийн захиргааны хууль, дүрмийн ёсоор аймаг, хошуу, сум, баг, арван гэр хүртэл олон хотын газар **орон нутгийн хурал** байгуулбал зохино.

Гучин нэгдүгээр зүйл: Нутгийн хурал нь аливаа аж ахуй ба албаны хэргүүдийг гүйцэтгэн явуулахаар өөрсдийн дундаас аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн аливаа хэрэг явдлыг гүйцэтгэх захиргааг сонгон байгуулбал зохих бөгөөд мөн албан хаагчдыг нэгэн жилийн хугацаагаар сонгон явуулбал зохино.

Гучин хоёрдугаар зүйл: Дээр дурьдсан аливаа захиргааны газрууд тус тусын орон нутгийн Хуралд хянан байцаагдвал зохино.

Гучин гуравдугаар зүйл: Аймаг, хошуу, сум, баг, арван гэрийн хурал ба захиргааны газруудын эрх хэмжээ, харилцах зэрэг явдлыг нутгийн захиргааны дүрэмд заасан ёсоор гүйцэтгэн явуулбал зохино.⁸ гэжээ.

Засаг захиргааны хуваарийг хийхдээ баг, сум, хошуу, аймаг хэмээн хувааж, тус бүрд нь хурал байгуулж, орон нутгийн засаг захиргааны эрхийг барих төлөөлөгчдийн систем тогтоосон ба энэ систем нь:

⁸ Монгол улсын үндсэн хууль. УБ. Монгол улсын 14 он. Тал 7

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

- Засаг дарга, сул ван, гүн, хутагт хувилгаан, түшмэл, тайж, ард гэж ялгаварлахгүй 10 өрхөөс бүрдэх I шат
- Харьят 5 багийн арван гэр тус бүрээс 2 төлөөлөгч сонгож байгуулах баг
- Харьят 3 багийн 15 арван гэр тус бүрээс 1 төлөөлөгч сонгож байгуулах сум
- 4 гэрээс дээш сум бүхий бол сум бүрээс 5, 3 ба түүнээс доош сум бүхий бол сум бүрээс 10 төлөөлөгч сонгож байх хошуу
- Жич тогтоох тооны төлөөлөгчдийн хошуудаас сонгож байгуулах, аймгийн хурал гэсэн 5 шаттай байв. Зарим нутгийн онцлогоос хамааран хурал нь 2-4 үе шаттай байсан нь бий.

Энэ зохион байгуулалтыг хийхдээ тухайн үеийн засаг захиргааны хуваарийг харгалзан хийсэн бөгөөд орон нутгийн эрх барихад ард түмний оролцоог бий болгож өгснөөрөө өмнөх тогтолцоотой харьцуулахад дэвшилттэй байв.

Орон нутгийн эрх барих байгууллагын түүхийг нэхэн үзэхэд мөн цаашдын хөгжлийг тодорхойлоход нөлөөлөх гол хүчин зүйл бол засаг захиргааны өөрчлөлтийн түүх юм. Өөрөөр хэлбэл засаг захиргааны хөгжлийг даган орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын хөгжилд чухал өөрчлөлтүүд гарсаар байв.

1931 онд БНМАУ-ын Орон нутгийн засаг захиргааны хуваарьт өөрчлөлт орж, хошууг татан буулгаж, 13 аймаг шинээр байгуулан, сумыг томруулсан явдал нь хурлын системд өөрчлөлт хийх түүхэн шаардлагыг бий бологсон байна.

1931 оны 2 сарын 27 нд Улсын бага хурлын тэргүүлэгчдийн тогтоол гарч, БНМАУ-ын шинэ хуваарийг батлав. Өмнө нь байсан 5 аймгийг өөрчилж, 13 аймаг шинээр байгуулан, хошуудыг татан буулгаж, оронд нь сумдыг томруулан байгуулж, тэдгээрийн эрх үүргийг өргөтгөжээ. Энэ шинэ хуваарь ёсоор аймаг нь сум сум нь багт хуваагдах болов. Засаг захиргааны өөрчлөлтийн дагуу хурлын систем нь:

I шат Хорины ба багийн

II шат Хорооны ба сумын

III шат Хотын ба аймгийн

IV шат УИХ гэсэн шаттай болжээ.⁹

Энэ үйл явцыг академич Ж.Болдбаатар, доктор Д.Лүндээжанцан нарын эрдэмтэд “Ардын хурлын зорилт нь улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, соёлыг хөгжүүлэх тодорхой бодлого зорилтыг тогтоох ба түүний биелэлтийг хянан шалгах, төрийн гүйцэтгэн захирах

⁹Б. Пүрэв. Социалист төрийн эрх барих тухай ленинч сургаал БНМАУ-д хэрэгжсэн нь. УБ. 1981. 33-р тал

байгууллагыг сонгон байгуулж, тэдгээрийг өөртөө бүрэн захирах зарчмыг хэрэгжүүлэхэд оршиж байв.”¹⁰ хэмээн төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын зорилго, чиглэлийг тодорхойлсон байна.

Түүнчлэн 1934 онд Алтай аймгийг татан буулгаж, 1940 онд эргээд байгуулан, Сэлэнгэ, Хөвсгөл аймгаас таслан Булган аймгийг казак, урианхай иргэдээс бүрдсэн Баян-Өлгий аймгийг тус тус байгуулсан нь орон нутгийн төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тогтолцоонд өөрчлөлт оруулсан түүхэн үйл явц болсон юм.

1940 оны Үндсэн хуулийн III зүйлд БНМАУ-ын засгийн бүх эрх нь хөдөлмөрчдийн хурлаар уламжлагдан хот хөдөөгийн хөдөлмөрчдийн гарт байна хэмээн зааснаар энэ үеэс хурал нь “Хөдөлмөрчин ардын хурал” нэртэйгээр түүхэнд үлджээ.

1940 оны, БНМАУ-ын Үндсэн хуулийн зургадугаар бүлэгт “Төрийн эрхийг барих орон нутгийн байгууллагууд” хэмээгээд аймаг, сум, баг, Улаанбаатар хот, хороо хоринд төрийн эрхийг барих дээд байгууллагууд нь хөдөлмөрчдийн депутатын хурал мөн гэж заагаад бүх шатны Хурлыг хоёр жилийн хугацаатай сонгох, гучин мянга хүртэл хүн амтай аймагт 50 депутат, түүнээс дээш хүн амтай аймагт 600 хүн тутмаас нэжгээд депутат, 3000 хүртэл хүн амтай сум, хороодод 100 хүн тутмаас нэжгээд депутат байх, харин нийт депутатын тоо 50-иас үл хэтрэх, 400 хүртэл хүн амтай баг, хороодод 7 депутат, үүнээс дээш хүн амтай бол 5 хүн тутмаас нэг депутат сонгохоор тогтоожээ.¹¹

Өдөр тутмын байнгын ажлыг эрхлэхийн тулд аймгийн ХДХ-ын Гүйцэтгэх захиргааг өөрсдийн депутат дотроос /дарга, орлогч дарга, хариуцлагатай нарийн бичгийн даргыг оруулан /7-9 хүртэл хүнээр бүрдүүлэн сонгох, мөн сум, хороонд 5-7 хүнээр гүйцэтгэх захиргааг Хурлаас нь бүрдүүлж өгөхөөр заажээ.

Мөн хуулийн 52-р зүйлд “Аймаг, сум, баг, хороо, хорины ХДХ-ууд нь харъяа нутаг дэвсгэр дээрээ соёл, улс төр, аж ахуйн байгуулалтыг удирдах, орон нутгийн төсвийг тогтоох, харъяа захиргааны газруудын ажиллагааг удирдах, улсын ёс дэглэмийг хамгаалах, хуулийг сахин дагах, ард иргэний эрхийг хамгаалах явдлыг хангана”¹² гэж чиг үүргийг нь тодорхойлсон байна.

Түүнчлэн БНМАУ нь 14 аймаг, Улаанбаатар хотоос бүрэлдэх бөгөөд аймгууд нь сумдад, сумууд нь багуудад, Улаанбаатар хот нь хороодод хуваагдаж байхаар засаг захиргаа нутаг

¹⁰ Болдбаат ар.Ж. Д.Лүндээжанцан. Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал.УБ.1997.тал 238

¹¹ Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004. тал 150

¹² Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004. тал 150

III МОНГОЛЫН ОЙРХИ ТҮҮХИЙН АСУУДЛУУД

дэвсгэрийн нэгжийг тогтоож өгсөн. Хөдөлмөрчдийн гарт орон нутгийн эрх барих байгууллага төвлөрөх ёстой гэсэн эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн байна.

Харин 1949 онд хуралдсан БНМАУ-ын IX Их Хурлын тогтоолоор Үндсэн хуулийн энэ бүлэгт нэмэлт өөрчлөлт оруулж Бүх шатны Хурлуудыг доод Хурлуудаас сонгогдсон төлөөлөгчдөөр байгуулах, аймаг, хотын хөдөлмөрчин ардын тогтмол Их Хурлууд нь 3 жилд нэг удаа, сум, хороо, баг, хорины төлөөлөгчдийн тайлан илтгэлийн ба сонгуулийн тогтмол Хурлууд нь жилд нэг удаа хуралдах, тогтмол бус хурлуудыг аймаг, хот, сум, хороо, баг, хорьдын бүх сонгуулийн эрхтэй хүмүүсийн хагас хувиас доош буюу мөн хурлаар сонгогдсон засаг захиргааны байгууллагын гуравны хоёр хувиас доошгүй нь шаардах буюу БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн даалгавраар зарлан хуралдуулахаар өөрчилжээ. Мөн аймаг, хотын Хурлуудын завсар цагт засаг захиргааны эрх барих дээд байгууллага нь аймаг, хотын ардын Их Хурлуудаас 3 жилийн хугацаагаар 1000 хүн дутмаас нэг гишүүнээр сонгогдсон бага хурлууд болно гэж шинээр заав. Энэ бага Хурлууд жилд хоёр удаа хуралдана. Өдөр тутмын ажлаа эрхлүүлэхийн тулд аймаг, хотын бага Хурлууд нь өөрийн гишүүдийн дотроос 7-13 хүртэл хүмүүсээр Тэргүүлэгч сонгох, үүнд: дарга, орлогч дарга ба гишүүдээр тус тус бүрдүүлэн сонгоно.

Сум, хороо, баг, хорьдын Хурлуудын гүйцэтгэн захирах байгууллагууд нь мөн Хурлуудаас 3-13 хүртэл хүнээр нэг жилийн хугацаатай сонгогдсон орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болох бөгөөд үүний бүрэлдэхүүн нь дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, захиргааны гишүүд болно. Захиргааны дарга нар нь бүхий л ажил, хэргүүдийг удирдах хийгээд захиргаадын хурлуудыг зарлан хуралдуулах ба мөн хурлуудыг удирдан даргална гэж заасан.

1924-1940 он хүртэл хэрэгжсэн Үндсэн хуулийн агуулга, үзэл баримтлал нь гүйцэтгэн захирамжлах байгууллагын үүргийг өргөтгөсөн, удирдлагын босоо тогтолцоог бэхжүүлсэн байдал ажиглагдаж байна.

Анхдугаар Үндсэн хуулиар “Орон нутгийн хурал” гэж нэрлэснийг 1949 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр аймаг, хотын “Хөдөлмөрчин ардын хурал” болгон өөрчилснийг ард иргэдийн оролцоог төлөөллийн байгууллагаар нь дамжуулан илүү идэвхтэй, үр нөлөөтэй ажиллуулахад анхаарсан хэрэг гэж үзэж болох талтай.

1940 оны Үндсэн хуульд орон нутгийн Хурлыг “Хөдөлмөрчин ардын хурал”, “Хөдөлмөрчдийн Депутатын хурал” хэмээн нэрлэж байсан нь нутгийн хурлын нэр хүнд байр суурь, үйл ажиллагааг баяжуулан хэрэгжүүлж байсны тодорхой жишээ юм.

1950-иад оны эцсээр сум нь хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хувьд үндсэндээ нэг нэгдэл буюу сангийн аж ахуйгаас бүрдэх болсныг харгалзан 1959 оны VIII сард багийг татан буулгаснаар сум, хороо нь орон нутгийн анхан шатны нэгж болов.¹³ Түүнчлэн хотын хүн амын өсөлтийг харгалзан 1965 оноос хороодыг татан буулгаж, анхан шатны нэгж нь район болсон түүхтэй. Үүнээс үндэслэн нийслэл дэх захиргааны нийтлэг эрх хэмжээтэй анхан шатны байгууллага нь районы АДХ-ын Гүйцэтгэх захиргаа болж¹⁴ нийслэл хотод шинээр районууд байгуулагдсан байна.

Улсын IX их хуралд Ерөнхий сайдын нэгдүгээр орлогч Ю.Цэдэнбалаас их хуралд тавьсан илтгэлд дурдахдаа “Ард түмнээс улсын байгууллагад сонгогдсон хүнийг цаашид депутат гэж нэрлэх болно. Энэ учраас манай засаг төрийн байгууллагууд нь Хөдөлмөрчдийн депутатуудын хурал” гэж нэрлэнэ¹⁵ гэснээр 1949 онд хуралдсан Улсын IX их хурлын материалуудын БНМАУ-ын сонгуулийн системийн I бүлэгт ... Ард түмнээс улсын байгууллагад сонгогдсон хүмүүсийг цаашид “депутат” /Депутат гэдэг нь ардын төлөөлөгч гэсэн үг/ гэж нэрлэх болно. Энэ учраас манай засаг төрийн байгууллагууд нь Хөдөлмөрчдийн депутатын хурал /ХДХ/ гэж нэрлэгдэх бөгөөд үүнийг доод шатны байгууллагаас эхлэн тодорхойлбол:

1. Багийн ХДХ
2. Сумын ХДХ
3. Аймагийн ХДХ

Хотод: 1. Хорины ХДХ

2. Хорооны ХДХ

3. Хотын ХДХ гэх болно.¹⁶ хэмээн тодорхойлсноор энэ үеэс орон нутгийн эрх барих байгууллагын бүтэц, эрх, үүрэг улам тодорхой болсон байна.

Түүнчлэн ХДХ нь ажлаа чуулганы журмаар зохион байгуулах, гүйцэтгэх захиргаатай болсон ба сонгох хүмүүсийн нормыг нарийн тогтоож өгсөн онцлогтой.

¹³ Ж.Болдбаатар.Д.Лүндээжанцан. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ.1997. 317 тал

¹⁴ Мөн тэнд тал 314

¹⁵ Б.Пүрэв. Социалист төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тухай ленинч сургаал БНМАУ-д хэрэгжсэн нь. УБ.1981. 34 тал

¹⁶ УТА.Хөмрөг-11.ДН№1.ХН-1139.Х-37. 15 тал

Үндсэн хуулийн 51-р зүйлд “Орон нутгийн Хөдөлмөрчдийн Депутатын хурлууд нь:

- Харьяа нутаг дэвсгэр дээрээ соёл, улс төр, аж ахуйн байгууллагыг удирдана
- Орон нутгийн төсвийг тодотгоно
- Харьяа захиргааны газруудын ажиллагааг удирдана
- Улсын ёс дэглэмийг хамгаалах, хуулийг сахин дагах, ард иргэний эрхийг хамгаалах явдлыг хангана¹⁷ хэмээн эрх, үүргийг нь улам тодорхой болгож өгсөн байна.

1960 оноос ХДХ өөрчлөгдөж, Ардын Депутатын хурал /АДХ/ нэртэй болсон бөгөөд үүнийг түүхэнд... УИХ-ын IV дэх удаагийн анхдугаар чуулганаар БНМАУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хэлэлцсэнээр Үндсэн хууль нь 10 бүлэг 94 зүйлээс бүрдэх бөгөөд УИХ гэж байсныг АИХ, аймаг, сум, хот, хороо, орон нутгийн хотын Хөдөлмөрчдийн Депутатын хурал гэж байсныг “Ардын Депутатын хурал” (АДХ) гэж нэрлэх болсон...¹⁸ байна.

1960 оны Үндсэн хуулийн тавдугаар бүлэг, 55-р зүйлд Аймаг, хот, сум, хорооны АДХ, түүний гүйцэтгэх захиргааны эрх үүргийг зааж өгсөн бөгөөд ХДХ-ын эрх, үүрэгтэй харьцуулахад илүү нарийссан гэж үзэж болох талтай. Үүнд: Дээрх ХДХ-ын адил эрх үүрэгтэй байхаас гадна Аж ахуй ба хоршооллын байгууллагын ажлыг хянан удирдана, улсын үйлдвэр, албан газар, ХАА-н нэгдэл, хоршооллын бусад байгууллагын эрх ашиг, мөн иргэний эрхийг хамгаална, хөдөлмөрчин олон түмнийг төр, аж ахуй, соёлын байгуулалтын бүх ажилд өргөн бөгөөд идэвхтэй оролцуулна¹⁹ хэмээн хуульчилж өгчээ.

Орон нутгийн эрх барих байгууллагын үүргийг өндөржүүлэн, АДХ хэмээн өөрчилснөөр 1990 он хүртэл энэ нэрээ хадгалан үйл ажиллагаагаа явуулсан ба АДХ-ын суурин дээр ИТХ-ыг байгуулан нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлж эхэлсэн байна.

Ийнхүү 1990 он гарсаар нэр томъёоны тухайд ч бүтэц, эрх үүргийн тухайд ч ардчиллын мөн чанарыг өөртөө агуулсан өнөөгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эх үүсвэр болох орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллага нь 1921 оны хувьсгалаас хойш мөн чанараа олж, 1940 оноос хойш жинхэнэ утгаараа хөгжин өнөөг хүрсэн нь Монголын улс төрийн түүхэнд гарсан чухал үйл явц болсон юм.

Бид энэ удаагийнхаа өгүүлэлдээ орон нутгийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын үүсэл, хөгжлийн тухайд хөндөн үзсэн бөгөөд цаашид орон нутгийн эрх барих байгууллагын

¹⁷ Б.Дашцэрэн. Орон нутгийн хөдөлмөрчдийн депутатын хурал.УБ. 1955.7 тал

¹⁸ Тэрбиш.Ц.Монголын парламентын үүсэл хөгжил. УБ. 2003.138-р тал

¹⁹ Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004. тал 258

үндсэн хэлбэр, сонгуулийн тогтолцоо, Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, эерэг, сөрөг талыг судлан тодруулж, түүхийн шинжлэх ухааны шинэ хандлагад нийцүүлэхийг зорьж буй билээ.

Abstract

The research covers the history of local administrative organizations so called public assembly, labourer's public assembly, labour representative's assembly, public representative's assembly and historical development of their structure and legal status.

Ном зүй

1. УТА.Хөмрөг-11.Д№1.ХН-1139.Х-37
2. Авирмэд.Э. БНМАУ-ын төрийн түүх. УБ.,1965
3. Амарсанаа.Ж. Батсайхан. О. Монгол улсын үндсэн хууль. УБ.2004
4. Ардын засгаас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд.УБ.,1954
5. Болдбаатар.Ж. Лүндээжанцан.Д. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал. УБ.1997
6. Гончигдорж.Х.Монгол улсад Орон нутгийн засаг захиргааны байгууллага байгуулсан нь.УБ.,1956
7. Дашням.И.БНМАУ-ын төрийн эрх барих байгууллагууд.УБ.,1978
8. Дашцэрэн.Б. Орон нутгийн хөдөлмөрчдийн депутатын хурал.УБ. 1955
9. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд.1920-1940.УБ.1966
10. Монгол улсын нутгийн захиргааны шинэчлэн тогтоосон дүрэм. УБ.1925
11. Монгол улсын үндсэн хууль. УБ.Монгол улсын 14 он
12. Улс төрийн шинжлэх ухааны үндэс. УБ.,1992
13. Улс төр судлал. 1 дэвтэр. УБ., 1996
14. Пүрэв.Б. Социалист төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагын тухай ленинч сургаал БНМАУ-д хэрэгжсэн нь. УБ.1981
15. Санждорж. М. Ардын төрийн түүх. УБ.1974
16. Сономдавга.Ц. БНМАУ-ын Орон нутгийн засаг захиргааны хуваарьт гарсан өөрчлөлтүүд.УБ.1967
17. Чимид.Б.Амархүү.О.Ардын төр.УБ.,1952

M.Javzansuren: "The establishment of local representative and administrative organizations"